

ҮБХИС-ийн захирлын 2023 оны
05 дугаар сарын 14 өдрийн
дугаар тушаалын хавсралт

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН
БАКАЛАВРЫН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
ХӨТӨЛБӨРИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар Үндэсний батлан хамгаалахын их сургууль /цаашид ҮБХИС гэх/-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын элсэлтийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/540 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, мөн сайдын 2023 оны “Босго оноо тогтоох тухай” А/97 дугаар тушаал, Батлан Хамгаалахын сайдын 2020 оны А/77 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм”-ийн 11.7.1, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирлын 2019 оны А/139 дүгээр тушаалаар баталсан “Дээд боловсролын бакалаврын зэрэг олгох сургалтын журам”-ын 2.2.7 дугаар заалт болон энэхүү журмыг удирдлага болгон элсэлтийг зохион байгуулна.

1.3. ҮБХИС-ийн бакалаврын болон мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийг зохион байгуулахаар томилогдсон төв болон бакалаврын, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн комиссыг “элсэлтийн төв болон салбар комисс”, элсэлтийн үйл ажиллагаанд оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.

1.4. Энэхүү журмыг ҮБХИС-ийн <http://mndu.gov.mn/bhis1/mn/elselt-2023/> болон <http://mndu.gov.mn> цахим хаяг болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд байршуулан, бүртгүүлэхийг хүсэгчдэд танилцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.5. Журмын хэрэгжилтэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, олон нийт, эцэг, эхийн төлөөлөл, ҮБХИС-ийн удирдлагын зүгээс хөндлөнгийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.6. ҮБХИС-ийн элсэлтийг цахимаар болон өөрийн биеэр ирж бүртгүүлэхээр зохион байгуулна. Элсэлтийн үйл ажиллагааг Боловсрол Шинжлэх Ухааны яамнаас тогтоосон өдрөөс эхлэн ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулна.

1.7. ҮБХИС-ийн бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Цэргийн нэгдсэн дээд сургууль, Аюулгүй байдлын дээд сургууль, Цэргийн хөгжмийн политехник коллеж, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Цэргийн хөгжмийн политехник коллеж, Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.

1.8. Бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт элсүүлэх хяналтын тоог захиалагч байгууллага тогтооно.

1.9. Бакалаврын хөтөлбөр:

ҮБХИС-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн бакалаврын хөтөлбөрүүдийн элсэлтийг иргэний болон цэрэг, батлан хамгаалахын гэсэн үндсэн хоёр чиглэлээр зохион байгуулна.

Аюулгүй байдлын дээд сургуульд: - Байгаль, нийгмийн шинжлэх ухаанд суурилсан дараах мэргэжлээр иргэний боловсролын бакалаврын зэрэг олгох хөтөлбөрүүдэд элсэлт авна.

Үүнд:

- Олон улсын харилцаа;
- Авто инженерчлэл*;
- Авто замын инженерчлэл;
- Электроникийн инженерчлэл*;
- Кибер аюулгүй байдал;
- Нийтийн удирдлага;
- Менежмент;
- Эдийн засаг.

Иргэний чиглэлийн бакалаврын хөтөлбөрүүдэд элсэгч нь “Цэргийн албаны тухай” Монгол Улсын хуулийн дагуу суралцах хугацаандаа цэргийн мэргэжил олгох сургалтад бүрэн хамрагдан, хугацаат цэргийн алба хаасанд тооцогдож, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдэх боломжтой. Цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан нь бие бялдар, эрүүл мэндийн хувьд хугацаат цэргийн алба хаагчдад тавигдах шаардлагыг хангасан байна.

Аюулгүй байдлын дээд сургуульд батлан хамгаалах салбарт эрэлттэй, цэргийн чухал мэргэжлээр суралцаж буй 4 дүгээр ангийн оюутнуудыг бэлтгэл офицерын сургалтад хамруулж, бэлтгэл офицeroор төгсгөж болно.

Аюулгүй байдлын дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагч нь 1, 2, 3 дугаар ангидаа ОХУ, БНХАУ, ХБНГУ, ТУРК УЛС, БНЭУ, ЯПОН УЛС, БНСУ зэрэг орнуудтай байгуулсан гэрээний дагуу БХЯ, ЗХЖШ-аас ирүүлсэн захиалгыг үндэслэн дээрх улсуудын цэргийн сургуулиудын сонгон шалгаруулалтад оролцож тэнцсэн тохиолдолд үнэ төлбөргүй суралцах боломжтой.

Цэргийн нэгдсэн дээд сургууль, Цэргийн хөгжмийн политехник коллеж /цэрэг, батлан хамгаалахын чиглэлээр/:

Зэвсэгт хүчин, төрийн цэргийн байгууллагын офицерын албанд ажиллах хүсэл, эрмэлзэлтэй, бие хүний төлөвшил, бие бялдар, эрүүл мэндийн тусгай шаардлага хангасан иргэнийг захиалагч байгууллагуудын мэргэжил, хяналтын тоо, захиалгын дагуу элсүүлэн үнэ төлбөргүй суралцуулж, цэргийн ухааны бакалаврын зэрэг олгож, дэслэгч цолтой төгсгөнө.

Үүнд:

- Ерөнхий цэргийн команд*;
- Артиллерийн команд*;
- Хуягт танкийн команд;
- Хуягт танкийн техникийн ашиглалтын инженер;
- Цэргийн холбооны инженер*;
- Цэргийн инженер;
- Цэргийн автотехникийн ашиглалтын инженер;
- Цацраг, хими, биологийн хамгаалалт хангалт;
- Зенитийн пуужингийн ашиглалтын инженер;
- Радиотехникийн команд*;
- Кибер аюулгүй байдал;
- Цэргийн соёл хүмүүжлийн ажилтан;
- Цэргийн хөгжмийн удирдаач;
- Цэргийн зэвсэглэлийн ашиглалтын инженер;
- Цэргийн материал хангалтын мэргэжилтэн.

1.10. Мэргэжлийн боловсролын хөтөлбөр:

а. Цэргийн хөгжмийн политехник коллеж /ЦХПК/ нь үлээвэр, цохивор найрал хөгжмийн хөгжимчин /мэргэжлийн боловсрол/-ий хөтөлбөрт Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр анги төгссөн хөгжмийн авьяастай сурагчдыг элсүүлэн, үлээвэр, цохивор найрал хөгжмийн сурагчаар үнэ төлбөргүй 2,5 жил суралцуулж “Мэргэжлийн боловсролын үнэмлэх”, үргэлжлүүлэн 1,5 жил суралцуулж “Техникийн боловсролын диплом” олгож, дэд ахлагч цолтой төгсгөнө.

б. Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв /БХМСҮТ/ нь цэргийн зэвсэглэл, техник, тусгай тоноглол, төхөөрөмжийн чиглэлээр мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт **25** хүртэлх насны иргэдийг элсүүлэн 1 жилийн хугацаанд үнэ төлбөргүй суралцуулж, цэргийн мэргэжил эзэмшүүлэн Зэвсэгт хүчний ахлагчийн албанд шилжүүлнэ. Үүнд:

- Явган цэргийн байлдааны машины механик жолооч;
- Явган цэргийн байлдааны машины наводчик оператор;
- Танкийн механик жолооч;
- Хуягт тээвэрлэгчийн механик жолооч;
- Артиллерийн бууны наводчик;
- Цахилгаан холбоо, компьютер сүлжээний техникч;
- Радиотелеграфчин;
- Зэвсгийн засварчин-нярав;
- Химичин зааварлагч;
- Инженерийн дугуйт машины механик жолооч;
- Автотехникийн цахилгаанчин;
- Радиолакацын станцын оператор-планшетчин;
- Автотехникийн засварчин-нярав;
- Хуягт танкийн техникийн цахилгаанчин-засварчин;
- Тагнуулчин-гал засварлагч /Артиллерийн тагнуулчин-гал засварлагч/.

Хоёр. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

А. Бүртгүүлэгчдэд тавих нийтлэг шаардлага

2.1. Элсэхээр бүртгүүлэгч нь өөрийн хүсэл сонирхол, итгэл үнэмшлээрээ сонголтоо хийсэн, бие бялдар, “Элсэлтийн ерөнхий шалгалт” /ЭЕШ/-ын босго онооны шаардлагыг хангасан, ёс суртахууны зөв төлөвшилтэй, суурь өвчингүй, Монгол Улсын хууль тогтоомж, нийгмийн хэв журмыг сахиж биелүүлдэг, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой Монгол Улсын иргэн байна.

2.2. Цэргийн мэргэжлийн бакапаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй дараах элсэгчдэд элсэлтийн ерөнхий шалгалтын оноо шаардахгүй. Үүнд:

а. Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг төгссөн онцгойлох дүнтэй төгссөн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид 1-ээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төгсөгч мэргэжлийн дагуу дэвшин суралцах;

б. Цэргийн хөгжмийн удирдаач хөтөлбөрт элсэх ур чадварын шаардлагыг хангасан, үлээвэр, цохивор, найрал хөгжмийн хөгжимчний мэргэжлийн дипломтой, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан **25** хүртэлх насны хөгжимчин ахлагч нар;

с. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн;

д. Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог БҮТ-өөр дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;

е. Элсэн суралцах мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ээр 5-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн.

2.3. Орон нутгаас суралцагч элсүүлэх хуваарьт зөвхөн тухайн аймагт оршин суугаа иргэд, Улаанбаатар хотоос элсүүлэх хуваарьт нийслэл хотод оршин суудаг харьяаллын бүртгэлтэй ЭЕШ өгсөн иргэд бүртгүүлнэ.

2.4. Орон нутагт ЭЕШ өгсөн бүртгүүлэгч Улаанбаатар хотын элсэлтэд хамрагдах тохиолдолд БҮТ-д бүртгүүлсэн байна.

2.5. Цэргийн мэргэжлээр бүртгүүлэгч орон нутагт тухайн аймгийн ЗДТГ-ын цэргийн штаб дээр, Улаанбаатар хотод ҮБХИС-ийн байрлалд тус тус өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

2.6. Бүртгүүлэгч сонгосон хөтөлбөрт хамаарах элсэлтийн шалгалтын хичээлээр 2021, 2022, 2023 онд ЭЕШ өгсөн аль нэг батламжаар элсэн суралцах эрх эдэлнэ.

2.7. Бүртгүүлэгч ҮБХИС-д бүртгүүлэхээс өмнө элсэлтийн ЭЕШ-ын шалгуулагчийн буланд нэвтэрч, өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцаж, зөрчилтэй асуудал байвал урьдчилан шийдвэрлүүлсэн байна.

2.8. Цэргийн мэргэжлийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт бүртгүүлэгч эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, энэ журмын хүснэгт 5-д заасан ур чадварын шалгалт өгнө. /Ур чадварын шалгалтын үнэлгээг Элсэлтийн ерөнхий шалгалтын 2 дахь хичээлийн дүнд тооцно/

2.9. АБДС-д иргэний мэргэжлээр бүртгүүлэгчдийн элсэлтийг цахимаар болон орон нутагт тухайн аймгийн ЗДТГ-ын цэргийн штаб дээр, Улаанбаатар хотод ҮБХИС-ийн байрлалд өөрийн биеэр ирж бүртгүүлэхээр зохион байгуулна.

2.10. Бакалаврын хөтөлбөрт бүртгүүлэгч нь тухайн хөтөлбөрт орох элсэлтийн шалгалтын нэгдүгээр хичээлүүдээс 1, хоёрдугаар хичээлүүдээс 1 хичээлийн босго оноог хангасан байна.

2.11. Гадаад улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн Монгол Улсын иргэнийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын элсэлтийн ерөнхий шалгалттай дүйцэх шалгалт өгсөн тухай тодорхойлолтыг үндэслэн элсүүлнэ.

Б. Цэргийн мэргэжлийн хөтөлбөрт элсэгчдэд тавигдах тусгай шаардлага

2.12. Цэргийн мэргэжлийн бакалаврын хөтөлбөрт **17-22** насны иргэнийг /эрэгтэй/ элсүүлэн цэргийн бакалаврын зэрэг эзэмшүүлнэ.

2.13. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт ЭЕШ өгсөн **25** хүртэлх насны иргэдийг элсүүлэн цэргийн тусгай мэргэжил эзэмшүүлнэ.

2.14. Цэргийн мэргэжлээр бакалаврын болон мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгч нь **165 см-ээс** дээш өндөртэй, **60 кг-аас** багагүй жинтэй, ямар нэг гаж зуршилгүй, сэтгэц эрүүл байх шаардлагыг хангасан байвал зохино.

2.15. Бакалаврын хөтөлбөрт элсэлтийн шаардлага хангасан ахлагч, Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэлтийн шаардлага хангасан цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдыг ЗХЖШ-ын даргын цэргийн албанаас халсан тухай тушаал, анги, байгууллагын албан бичиг, гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотлох цагдаагийн байгууллагын тодорхойлолт зэргийг үндэслэн элсүүлэн суралцуулна.

2.16. Монгол Улсын засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ын дагуу биед шивээсгүй, сэтгэцээс үүдэлтэй сорвигүй нөхцөлд цэргийн сургуульд сонсогчоор элсүүлнэ.

2.17. Эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон хүлээж байгаа иргэнийг тус сургуулийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт элсүүлэн суралцуулахгүй.

Гурав. Элсэлт авах хөтөлбөр, босго оноо

3.1. Үндсэн бүлэг /бакалаврын хөтөлбөр/

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЭД СУРГУУЛЬ /ИРГЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР/

Хүснэгт 1

№	Хөтөлбөр	Элсэлтийн шалгалтын хичээл, босго оноо			
		I-хичээл		II-хичээл	
1	Олон улсын харилцаа	Англи хэл, Орос хэл	480	Нийгэм судлал, Түүх	480
2	Авто инженерчлэл	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
3	Авто замын инженерчлэл	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
4	Электроникийн инженерчлэл	Физик, Математик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
5	Кибер аюулгүй байдал	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
6	Менежмент	Математик	480	Англи хэл	480
7	Нийтийн удирдлага	Нийгэм судлал	480	Англи хэл, Нийгэм судлал	480
8	Эдийн засаг	Математик	480	Физик, Англи хэл	480

ЦЭРГИЙН НЭГДСЭН ДЭЭД СУРГУУЛЬ, ЦЭРГИЙН ХӨГЖМИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ /ЦЭРЭГ, БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР/

Хүснэгт 2

№	Хөтөлбөрийн нэр	Цэргийн мэргэжлийн ангилал	Элсэлтийн шалгалтын хичээл, босго оноо			
			I-хичээл		II-хичээл	
1	Хуурай замын цэргийн сургалт	Ерөнхий цэргийн команд	Нийгэм судлал, Математик	480	Ур чадвар	480
2		Артиллерийн команд	Математик	480		
3		Хуягт танкийн команд	Математик	480		
4		Хуягт танкийн техникийн ашиглалтын инженер	Математик, Физик	480		
5		Цэргийн холбооны инженер	Физик, Математик	480		
6		Цэргийн инженер	Математик	480		
7		Цэргийн автотехникийн ашиглалтын инженер	Математик Физик	480		
8		Цацраг, хими, биологийн хамгаалалт, хангалт	Хими, Биологи	480		
9	Агаарын цэргийн сургалт	Зенитийн пуужингийн ашиглалтын инженер	Физик, Математик	480	Ур чадвар	480
10		Радиотехникийн команд	Физик, Математик	480		
11	Кибер аюулгүй байдлын цэргийн сургалт	Кибер аюулгүй байдал	Математик, Физик	480	Ур чадвар	480

12	Батлан хамгаалах	Цэргийн соёл, хүмүүжлийн ажилтан	Нийгэм судлал, Математик	480	Ур чадвар	480
13		Цэргийн хөгжмийн удирдаач	үлээвэр, цохивор, найрал хөгжмийн хөгжимчний мэргэжлийн дипломтой		Ур чадвар	480
14	Цэргийн шинжлэх ухаан	Цэргийн зэвсэглэлийн ашиглалтын инженер	Математик	480	Ур чадвар	480
15		Цэргийн материал хангалтын мэргэжилтэн	Математик	480		

3.2. Тусгай бүлэг /мэргэжлийн боловсролын хөтөлбөр/

ЦЭРГИЙН ХӨГЖМИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Хүснэгт 3

I-хичээл	II-хичээл	Нэмэлт шалгуур	Босго оноо
Математик	Монгол хэл	Эрүүл мэндийн үзлэг, ур чадварын шалгалт	Шалгалтыг 100% гэж тооцон 70%-иас дээш амжилт үзүүлбэл тэнцэх шалгуурыг хангасан

БАТЛАН ХАМГААЛАХЫН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

Хүснэгт 4

I-хичээл	II-хичээл	Нэмэлт шалгуур	Босго оноо
Математик, физик, хими /аль нэг хичээлээр ЭЕШ өгсөн байна./	Ур чадвар	Эрүүл мэндийн үзлэг	Ур чадварын шалгалтын босго оноо 480

3.3. Сургалт, эрдэм шинжилгээ, спорт, зохион бүтээх инженерчлэлийн чиглэлээр олон улсын хэмжээний олимпиад, уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан элсэхийг хүсэгчдэд тус сургуульд элсэн суралцах босго оноог хангасан тохиолдолд “Ур чадварын шалгалт”-ыг дүйцүүлэн тооцно.

/Цэргийн албаны тухай Монгол Улсын хуулийн 9.5 заалтын дагуу энэхүү цэргийн мэргэжлийн хөтөлбөрт суралцагчдын ахуй хангалт, дүрэмт хувцас, сургалтын төлбөрийг төр хариуцна/

3.4. Босго /хэмжээст/ оноо нь хоёр хичээл тус бүрд **700-аас** дээш оноотой элсэгчдийг сургалтын төлбөрөөс **50%** чөлөөлөн элсүүлэн суралцуулна.

3.5. Ерөнхий боловсролын “Тэмүүжин-Өрлөг” бүрэн дунд сургуулийг төгсөгч бакалаврын хөтөлбөрт ЭЕШ-ын босго оноог хангасан тохиолдолд ур чадварын шалгалт өгөхгүй.

3.6. Ерөнхий боловсролын “Тэмүүжин-Өрлөг” бүрэн дунд сургуулийг төгсөгч мэргэжлийн боловсролын хөтөлбөрт эрүүл мэндийн шаардлага хангасан тохиолдолд ЭЕШ-ын оноогүй орж болно.

Дөрөв. Элсэлтийн бүртгэл

4.1. Аюулгүй байдлын дээд сургууль /иргэний чиглэлийн/-ийн элсэлтийн бүртгэлийг **цахимаар болон биеэр** ирж, цэргийн мэргэжлийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт элсэгч орон нутагт тухайн аймгийн ЗДТГ-ын цэргийн штаб дээр, Улаанбаатар хотод ҮБХИС дээр өөрийн **биеэр** ирж бүртгүүлнэ.

4.2. Элсэлтийн бүртгэл **2023 он 6 дугаар сарын 19-ний өдрийн 08.30** цагт эхэлж, **7 дугаар сарын 06-ны өдрийн 16.00** цагт дуусгавар болж хаагдана.

4.3. Улаанбаатар хотоос бүртгүүлэгч ҮБХИС-д эрүүл мэндийн үзлэг, ур чадварын шалгалтад тогтоосон хугацаанд өөрийн биеэр ирж хамрагдана.

4.4. Цэргийн мэргэжлийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт орон нутгаас бүртгүүлэгч тухайн аймгийн ЗДТГ-ын цэргийн штаб дээр тогтоосон хугацаанд ур чадварын шалгалтад өөрийн биеэр ирж хамрагдана. Орон нутгаас элсэгчдийн эрүүл мэндийн үзлэгийг Улаанбаатар хотод Цэргийн төв эмнэлэг дээр зохион байгуулна.

4.5. ЦХПК-ийн элсэлтийг зөвхөн Улаанбаатар хотод ҮБХИС дээр зохион байгуулна.

4.6. Элсэлтийн бүртгэлтэй холбоотой хүндрэлтэй асуудал үүссэн тохиолдолд элсэлтийн комисст хандаж шийдвэрлүүлнэ.

4.7. Хувь хүний өөрийн буруугаас болж үүссэн асуудлыг элсэлтийн комисс хариуцахгүй.

Тав. Элсэгчийг шалгаруулах

5.1. Цэргийн мэргэжлийн бакалаврын хөтөлбөрүүдэд босго оноог хангасан бүртгүүлэгчдээс сонгон шалгаруулалт хийхдээ **хүснэгт 2-д**, мэргэжлийн боловсролын хөтөлбөрт босго оноог хангасан бүртгүүлэгчдээс сонгон шалгаруулалт хийхдээ **хүснэгт 3-д** заасан шалгалтуудын оноог тус тус 100 хувиар бодон нэмж хэмжээст оноог тогтоож, онооны дарааллаар байр эзлүүлэн хуваарь сонгуулах журмыг баримтална. Жишээ нь: Тухайн сонгосон хөтөлбөрийн хоёр шалгалтын оноог 100 хувийн харьцаагаар нэмнэ. Элсэгч нэгдүгээр хичээлд 480 оноо, хоёрдугаар хичээл буюу **ур чадварын 480** оноо авсан гэж үзвэл таны нийлбэр оноо $x = 480 + 480 = 960$ оноо болно.

5.2. Иргэний мэргэжлийн бакалаврын хөтөлбөрүүдэд босго оноог хангасан бүртгүүлэгчдээс сонгон шалгаруулалт хийхдээ **хүснэгт 1-д** заасан шалгалтуудын оноог 100 хувиар бодон нэмж хэмжээст оноог тогтоож онооны дарааллаар байр эзлүүлэн хуваарь сонгуулах журмыг баримтална. Жишээ нь: Тухайн сонгосон хөтөлбөрийн хоёр шалгалтын оноог **100** хувийн харьцаагаар нэмнэ. Элсэгч нэгдүгээр хичээлд **480** оноо, хоёрдугаар хичээлд **500** оноо авсан гэж үзвэл таны нийлбэр оноо $x = 480 + 500 = 980$ оноо болно. Энэхүү оноо нь элсэгчийн ҮБХИС-д элсэхийг хүсэгчдээс шалгаруулалт хийх хэмжээст оноо болно.

5.3. Улаанбаатар хотод цэргийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт ЭЕШ-ын нэгдүгээр хичээлээр тэнцсэн элсэгчдийг **07 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд** Цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулна. (Тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан эрүүл мэндийн үзлэгт хамруулах хугацаа өөрчлөгдөж болно)

5.4. Ур чадварын шалгалтыг **07 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд** зохион байгуулна.

- “Үлээвэр, цохивор найрал хөгжмийн хөгжимчин” мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгчдээс ритм, сонсгол, авьяас чадварын шалгалт, Ерөнхий боловсролын 9 дүгээр ангийн түвшинд математик, монгол хэл хичээлүүдээр /хүснэгт 3/ шалгалт авч, эдгээр шалгалтыг 100% гэж тооцон 70%-иас дээш амжилт үзүүлбэл тэнцэх шалгуурыг хангасан гэж үзнэ.

- Орон нутагт цэргийн бакалаврын хөтөлбөр, цэргийн мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгчдээс авах ур чадварын шалгалтыг **7 дугаар сарын 06-нд** цэргийн штаб зохион байгуулна. (шалгалт авах байр, танхимыг бүртгэлийн үед мэдэгдэнэ).

УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, НОРМАТИВ

хүснэгт 5

№	Бие бялдрын чанарууд	Дасгалын төрөл	Аргачлал	Гүйцэтгэлийн үнэлгээ	Тэнцүүлэх үзүүлэлт	Тэнцүүлэх босго оноо
1.	Хүч	Дүүжинд суниах	Тоо	100%=800 оноо	8-аас дээш	480
2.		Гэдэсний таталт	Тоо	100%=800 оноо	40-өөс дээш	480
3.	Тэсвэр	1000 метрт гүйх	мин	100%=800 оноо	4.20 ^{ll} -аас дотогш	480
4.	Хурд	100 метрт гүйх	сек	100%=800 оноо	15.0-аас дотогш	480

Тайлбар: Дээрх 4 үзүүлэлтийн 3 ба түүнээс дээш дасгалыг биелүүлсэн тохиолдолд тэнцэнэ. 100 метр, 1000 метрийн гүйлтийн аль нэг дасгалд заавал тэнцсэн байвал зохино.

5.5. Хөтөлбөр бүрээр онооны дарааллаар байр эзлүүлж, хяналтын тоонд багтсан элсэгчдийг ЭЕШ-ын бүртгэлийн дугаараар мэдээллийн самбарт байршуулна.

5.6. Цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр эрүүл мэндээр тэнцэхгүй нь тогтоогдсон, бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй элсэгчдийг жагсаалтаас хасаж, онооны дарааллаар дараагийн бүртгүүлэгчид сонголтыг шилжүүлнэ.

5.7. Шалгалтын дүнг **7 дугаар сарын 07-ны өдрийн 12.00 цагт** нийтэд мэдээлнэ.

Зургаа. Элсэгчээр бүртгэх

6.1. Цэргийн мэргэжлийн бакалавр, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт тэнцсэн элсэгчдэд **7 дугаар сарын 07-ны 12.00-17.00 цагт** “ҮБХИС-д суралцах эрхийн бичиг” олгоно.

6.2. Иргэний мэргэжлээр бүртгүүлэгчдэд **2023 оны 08 дугаар сарын 22-нд** их сургууль дээр суралцах эрхийн бичгийг олгоно.

6.3. Иргэний мэргэжлээр амжилттай бүртгэгдэж, элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор тухайн сонгосон хөтөлбөрийн шаардлагыг хангасан элсэгч сургалтын төлбөрийг **50 хувь** төлж суралцах эрхээ баталгаажуулна.

6.4. Заасан хугацаанд ирж, суралцах эрхийн бичгээ аваагүй бүртгүүлэгчийг суралцахаас татгалзсанд тооцож, онооны дарааллаар дараагийн элсэгчид сонголтыг шилжүүлнэ.

6.5. Бүртгүүлэгч нь суралцах эрхийн бичиг авахдаа дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэх /хуулбараар/;
- ЭЕШ-ын батламж /хэвлэмэл байдлаар болон цахимаар/;
- Боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг /Суурь болон бүрэн дунд боловсролын гэрчилгээ/;
- Сурагчийн хувийн хэрэг;
- БХЯ, ЗХЖШ-ын зөвшөөрөл, анги байгууллагын тодорхойлолт /зөвхөн ахлагч нарт хамаарна/;
- 3x4 хэмжээний цээж зураг 4 хувь;
- Зан байдлын тухай төгссөн сургуулийн тодорхойлолт;
- Гурван үеийн намтар /Өөрийн болон эцэг, эхийн дэлгэрэнгүй намтарыг өөрийн гараар бичсэн байна/;
- гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотлох цагдаагийн байгууллагын тодорхойлолт /лавлагаа/;
- Системээс илгээсэн бүртгэлийн хуудас зэргийг бүрдүүлсэн байна.

6.6. Элсэгч нь “ҮБХИС-ийн дүрэм”-д заасан суралцагчдад тавигдах шаардлагын дагуу бүрэлдэхүүн сургуулийн захирал, Эрдэм шинжилгээ, сургалтын албатай “Суралцах гэрээ” байгуулна.

6.7. Суралцах эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

Долоо. Элсэлтийн шалгалтын зардал

7.1. Элсэхийг хүсэгч дор дурьдсан зардлыг хариуцна.

- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр;
- Сургалтын удирдлага, мэдээллийн систем ашиглалтын төлбөр;
- Цэргийн анхан шатны бэлтгэл сургалттай холбоотой зардал;
- Гэнэтийн ослын даатгалын төлбөр.

7.2. Элсэхийг хүсэгч цэргийн анхан шатны бэлтгэлийн дундаас орхисон тохиолдолд сургалтын явцад гарсан зардал болон их сургуулиас олгосон хувцас, ахуй хангалт, хүнсний зардлыг төлөх үүрэгтэй.

Найм. Өргөдөл, гомдол шийдвэрлэх

8.1. Элсэлттэй холбоотой өргөдөл, гомдлыг 07 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл, цэргийн анхан шатны бэлтгэлт сургалттай хамаарал бүхий өргөдөл, гомдлыг 08 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл тус тус хүлээн авна.

8.2. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

8.3. Өргөдөл, гомдлын хариуг биечлэн амаар буюу утсаар эсхүл бичгээр мэдэгдэнэ. Хариуг амаар, утсаар мэдэгдсэн тохиолдолд алба хаагч энэ тухай тэмдэглэл үйлдэж материалд хавсаргана.

Ес. Бусад

9.1. Орон нутгаас цэргийн мэргэжлийн хөтөлбөрүүдэд тэнцсэн элсэгчид:

- 7 дугаар сарын 24-ний өдөр Улаанбаатар хотод хүрэлцэн ирж ҮБХИС-ийн элсэлтийн комисст бүртгүүлнэ.

- 7 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Цэргийн төв эмнэлгийн цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамрагдана. /Элсэгч эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг Цэргийн төв эмнэлгээс тогтоосон үнийн тарифын дагуу хариуцан төлнө/

- 8 дугаар сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдаж, цэргийн тангараг өргөнө.

9.2. Иргэний мэргэжлээр элсэгчид сургалтын төлбөрийн 50 хувийг төлсөн тохиолдолд Их сургуулийн удирдлагын мэдээллийн “Cloud university V2” системд бүртгүүлэх эрх нээгдэж ҮБХИС-ийн оюутны код, үнэмлэх авах боломж бүрдэнэ.

9.3. Суралцах эрх авсан боловч заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр системийн бүртгэлд бүртгэлээ баталгаажуулаагүй элсэгчийг суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийг хүчингүйд тооцно.

9.4. Элсэлтийн цахим хуудас нь тогтмол ажиллагаатай нээлттэй үйлчилж элсэлттэй холбоотой мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.

9.5. Элсэгчдэд бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.

9.6. ҮБХИС-д суралцах нөхцөлийг хангасан “Бакалаврын зэргийн диплом”-той элсэгчдийг суралцуулах асуудлыг “ҮБХИС-д боловсролын бакалаврын зэрэг олгох сургалтын журам”-ыг үндэслэн хэрэгжүүлнэ.

Харилцах утас, мэйл хаяг:

- ҮБХИС-ийн Сургалтын хэлтэс: 453164, info@mndu.gov.mn
- ҮБХИС-ийн жижүүр: 480908
- Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Улаанхуаран
www.mndu.gov.mn/

СУРГАЛТЫН ХЭЛТЭС